

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР



## 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2013 он

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ



Засгийн газрын 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Монгол улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах Мэргэжлийн байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Худалдан авах ажиллагааны газар” 63 хүний бүтэц бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

### **Эрхэм зорилго:**

Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулахад оршино.

### **Үйл ажиллагааны зорилт:**

- Худалдан авах ажиллагааг ил тод, шударга болгох,
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцлийг хангах,
- Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх,
- Газрын болон орон нутгийн нэгжийн чадавхи, техник, технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх,
- Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, тэдэнд олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн сургалтыг тогтмол зохион байгуулах.

## БАЙГУУЛЛАГЫН 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ,БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

Тус газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Өрсөлдөөний

тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, зорилтыг хэрэгжүүлэн бодит ажил болгоход анхааран ажиллалаа.

Архив, албан хэрэг хөтлөлт, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт


Байгууллагад ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, шийдвэрлэлтэнд нь хяналт тавьж ажилласан.

Тайлант хугацаанд газрын даргын нийт 475 тушаал (Зураг 1.) гарсанаас:

- ✓ Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (үнэлгээний хороо байгуулах болон үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөх, Шууд гэрээ байгуулах ажлын хэсэг байгуулах тухай) - 311 тушаал,
- ✓ Хүний нөөцийн чиглэлээр (ажилд авах, чөлөөлөх, тэтгэлэг, чөлөө олгох, сахилгын шийтгэл оногдуулах, шагнах, албан томилолт олгох, сургалтанд хамруулах, туршлага судлуулах тухай г.м)- 124 тушаал,
- ✓ Дотоод үйл ажиллагааны холбогдолтой тухайлбал, шинэ жил, баяр тэмдэглэх, цаг үеийн бусад ажлын чиглэлээр нийт - 40 тушаал гарсан байна.
- ✓

Зураг 1.

2013 онд гарсан газрын даргын тушаал



Байгууллагад 2013 оны байдлаар нийт 2948 албан бичиг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба хариутай 315 албан бичигт тухай бүр зохих журмын дагуу хариу өгч, 126 албан бичгийг холбогдох байгууллагад уламжилж, 4500 албан бичиг төлөвлөн бусад байгууллагад хүргүүлсэн.

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 3 удаа гаргаж, удирдлага, хэлтсийн дарга нарт танилцуулсан нь хугацаатай бичгийг цаг алдалгүй шийдвэрлэж, хариуг холбогдох байгууллагад хүргүүлж хэвшихэд нөлөөлсөн.

Ирүүлсэн бичгийг ирүүлсэн байгууллагаар нь ангилж (Зураг 2.) үзвэл, яамдаас ирсэн бичиг-2126, Газар, агентлагаас ирсэн бичиг- 89, Нийслэлийн төр захиргааны байгууллага болон орон нутгаас ирсэн 57, тендерт оролцогч компаниас 676 тус тус ирсэн байна.

Зураг 2.

Ирсэн бичгийг байгууллагаар ангилсан байдал



Тус газарт холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд иргэд, байгууллагаас нийт 27 өргөдлийг бичгээр хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэн өргөдөл гаргагчид хариуг өгч ажиллав.

Иргэд байгууллага болон ажилтан, албан хаагчдаас бичгээр гаргасан өргөдлийн агуулгыг тоймлон (Хүснэгт 1.) үзүүлбэл:

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах болон үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлүүлэх тухай хүсэлт дийлэнх хувийг эзэлж, ажилд орох, чөлөөлөгдөх тухай хүсэлт тодорхой хувийг эзэлж байна.

Хүснэгт 1.

Ирсэн өргөдөл, гомдлын агуулга, бүтцийн судалгаа

Огноо: 2013/01/18-2013/12/05

№	Агуулга	Бичгээр	Цахим	Нийт	Нийт өргөдөлтэй харьцуулсан
1	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлүүлэх тухай хүсэлт	11	-	11	40,7%
2	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах тухай хүсэлт	3	-	3	11,1%
3	Ажлаас чөлөөлөгдөх тухай хүсэлт	5	-	5	18,5%
4	Бусад асуудлаар	8	-	8	29,6%
	<b>Нийт</b>	<b>27</b>	<b>-</b>	<b>27</b>	<b>100 %</b>

Засгийн газрын "11-11 төвд" 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн Худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар иргэдээс санал хүсэлтийг хүлээн авч нийт 70 санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэж ажилласан байна. Үүнээс: Утасны дуудлагаар 49, вэб сайтаар 13, твиттерээр 2, мессежээр 1, биечлэн 5 удаа хандаж, санал хүсэлт иргэдээс ирүүлсэн ба санал -58, гомдол-3, шүүмжлэл - 9 гаргасан бөгөөд тухай бүр зохих хариуг өгч хамтран ажиллав.

Байгууллагын үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж, ирсэн санал, хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулав. Тайлант хугацаанд "Санал хүсэлтийн хайрцаг"-т нийт 11 сэтгэгдэл ирснээс шүүмжлэл 5, санал 1,

хүсэлт 3, талархал 2 ирсэн байна. Хайрцагт ирсэн санал хүсэлтийг ХШҮДАХэлтэс хянан үзээд холбогдох хэлтэст танилцуулан шийдвэрлүүлж, эргэж холбоо барих утсаа үлдээсэн иргэдэд хариу өгч ажилласан. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй.



Ажилтнуудын “Албан хэрэг хөтлөлт”-ийн мэдлэг чадварыг сайжруулах үүднээс “Бичиг хэргийн булан” нээж 7 хоног бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд үүний үр дүнд ажилтнуудын албан хэрэг хөтлөлтийн мэдлэг, мэдээлэл сайжирч байна.

Байгууллагын 2013 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулан хэлтэс тус бүрд танилцуулан хэрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсны үр дүнд ажилтнуудад хөтлөгдөн үүссэн баримт бичиг бүрэн архивт шилжих нөхцөл бүрдээд байна.

Татварын ерөнхий газраас “Лавлагаа авах тухай”, Банкны “Баталгаа цуцлах тухай” албан бичгийг загвар, маягтанд оруулж мөрдүүлж хэвшүүлсэн. Байгууллагын “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг баримтлангазрын даргын тушаалаар байгуулсан.

Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн заалтын хэрэгжилтийг хангах үүднээс Гадаадын орон, олон улсын болон бусад байгууллагатай хамтран ажиллах 16 баримт бичгийн эх хувийг төрийн албан ёсны хэлээр үйлдүүлж, гадаад хэлээр орчуулгыг хавсарган хэрэг бүрдүүлсэн.

Удирдлагын түвшинд гарсан тушаал болон ирсэн явсан бичгээр 46 ширхэг хадгаламжийн нэгж үүсгэсэн. Тендерийн баримт бичгээр байнга хадгалах 531 ширхэг, түр хадгалах хадгаламжийн 893 нэгж хадгаламжийн нэгж үүсгэн үдэж хавтаслан бүртгэлд оруулсан. Архивын хадгалалт, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэх хүрээнд архивын стандартад нийцсэн өрөөг тохижуулан тоноглож ашиглаж эхлэв.

#### Тайлан мэдээ, зорилт, арга хэмжээний хэрэгжилт, биелэлтийн байдал

Тайлант хугацаанд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 7 хоног тутмын шуурхай хуралдаанд худалдан авах ажиллагааны явц, төлөвлөгөөний биелэлтийн талаар 26 удаа үүрэг даалгавар авч, биелэлтийг Шадар сайдын шуурхай хуралд танилцуулсан.

2013 онд хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын явцын талаар Засгийн газрын хуралдаанд 3 удаа танилцуулж, 2 тэмдэглэл, 2 тогтоол (Засгийн газрын 2013 оны 10, 13 дугаар тэмдэглэл, 90, 277 дугаар тогтоол) гарсан ба шийдвэрийг захиалагч нарт хүргүүлэн хэрэгжилтийг 100 % ханганажилласан.

Худалдан авах ажиллагааны газрын тухайн сард хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 удаа гарган өгч, биелэлтийн мэдээг дараа сар бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж Шадар сайдын ажлын лбанд хүргүүлсэнээс гадна төсвийн ерөнхийлөн захирагч, Улсын Их Хурлын гишүүдэд Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын 2013 онд зохион

байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан, орон нутагт хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдөр, 09 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар аймаг тус бүрээр гарган Шадар сайдын ажлын албаар уламжлуулан хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны улирлын тайланг улирал бүр гарган Сангийн яам, ШСАА-нд хүргүүлсэн. Мөн байгууллагын нэгдүгээр улирлын үйл ажиллагааны зорилт, биелэлт, үр дүнгийн талаарх тайланг Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн дагуу Худалдан авах ажиллагааны газрын хөрөнгө оруулалтад тусгагдсан үйлчилгээний байрны их засвар, тавилга эд хогшил, тоног төхөөрмж, тээврийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлан мэдээг тухай бүр Сангийн яам болон Шадар сайдын ажлын албанд, татвар, нийгмийн даатгалын шимтгэл, үйл ажиллагааны хүрээнд гарсан төлбөр тооцоог батлагдсан төсвийн хуваарьт багтаан төлж, тайлан мэдээг сар, улирал бүр гарган, Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Сангийн яам, Шадар сайдын Ажлын Албанд тайлагнан ажилласан.

Орон нутгийн худалдан авах ажиллагааны 31 нэгжийн 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаа, худалдан авалтын тайланг улирал бүр нэгтгэн холбогдох мэдээ, тайланд хамруулсан.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн дүн мэдээг 1, 2, 3-р улирлын байдлаар гарган журамд заасан хугацаанд ШСАА, ЗГХЭГ-ын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт албан бичгээр тус тус хүргүүлэв.

2013 оны 03 дугаар улирлын байдлаар (сүүлийн мэдээгээр) Худалдан авах ажиллагааны газар нь Засгийн газраас гаргасан нийт 43 шийдвэрийн 52 заалтыг бүртгэл-хяналтадавч хэрэгжүүлэв. 2013 оны 03 дугаар улирлын байдлаар мэдээлэгдсэн Засгийн газрын 10 шийдвэрийн 12 заалтын хэрэгжилт дундажаар 86,7 %-ийн хэрэгжилтийн явцтай байв. 03 дугаар улирлын байдлаар УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗөвлөлийн зөвлөмжийн заалтаар тус газарт даалгасан үүрэг даалгавар бүртгэгдээгүй.

Шинэчлэлийн Засгийн газраас гаргасан, манай байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хэрэгжиж байгаа шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд зориулан сар бүрийн 3 дахь 7 хоногт ЗГХЭГ-ын ХШҮДАГ газарт 09 дүгээр сараас эхлэн цахим хэлбэрээр хүргүүлж ажиллав. Үүнд:

- 09-р сард нийт 15 шийдвэрийн 19 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтсээс мэдээлэл гаргуулан авч, нэгтгэн боловсруулж, ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын референт Оргодол болон Шадар сайдын зөвлөх Цэрэндулам нарын нэр дээр цахим хэлбэрээр хүргүүлсэн.
- 10 дугаар сард 09 шийдвэрийн 11 заалтын хэрэгжилтийг, 11 дүгээр сард 6 шийдвэрийн 7 заалтын хэрэгжилтийг, 12 дугаар сард 6 шийдвэрийн 7 заалтын хэрэгжилтийг тус тус гарган ЗГХЭГ-т болон ШСАА-нд хүргүүлэв.

Шадар Сайдын Ажлын албатай холбогдон хамтарч ажиллах хүрээнд дараах шуурхай мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргүүлж ажиллав. Үүнд: Шадар Сайдын 2013-07-23-ны өдөр 2013 оны эхний хагас жилийн тайлангийн хурал дээр өгсөн 10 заалт бүхий үүрэг, чиглэлийн хэрэгжилт, 2012 онд зохион байгуулагдсан “Ард түмэн Та хаан” форумын



мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний /11 заалттай/ биелэлт, 2013 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр төлөвлөсөн асуудлуудын хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөнд тусгах ажлын санал, Засгийн газрын 2011 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт зэрэг болно.

Авлигын эсрэг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнийхэрэгжилт, 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох материалын хамт 11 дүгээр сарын 15-нд АТГ-т хүргүүлэн, байгууллагын энэ чиглэлээрх “Сайн туршлага” болохуйц ажлыг тодорхойлон АТГ-аас зарласан уралдаанд оролцсон бөгөөд 12 дугаар сарын 05-ны өдөр болсон “Ил тод худалдан авах ажиллагаа” сэдэвт салбарын хэмжээний дугуй ширээний ярилцлагад “Шилдэг туршлага” сэдвээр илтгэл тавьж, салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлын асуудлаар тулгамдаж байгаа шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлоход байгууллагын зүгээс 12 албан хаагчийг оролцуулав.

## НЭГ. ДОТООД АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

### Хүний нөөцийн чиглэлээр

Агентлагийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажлынбайрнышаардлагаднийцсэн мэдлэг чадвартай боловсон хүчнийг шилж, сонгон оновчтой байршуулахад байгууллагын хүний нөөцийн бодлогыг чиглүүлж ажиллав.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан УИХ, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн 20 гаруй тогтоол, шийдвэр, заавар журмын хүрээнд төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулан ажиллаж байна.

Албан хаагчдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой нийт 150 тушаал тайлант жилдгарсан. 49 ажилтан шинээр ажилд авч, 11 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн.

Төрийн албаны зөвлөлд захиалга өгч ажлын байрны сул орон тоог нөөцөөс нөхөх зар 2 удаа гаргуулж, 3 удаа төрийн албаны мэргэжлийн шалгалтыг зохион байгуулснаар туршилтын хугацаагаар ажиллаж байсан 15 ажилтнаас 9 ажилтан ажлын байраа хадгалж албан тушаалд томилогдсон.Дэд дарга, хэлтсийн дарга нарыг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилуулах хүсэлтийг ТА3-д тавьж шийдвэрлүүлэн 8 хэлтсийн даргад дүгнэлт гаргуулж,албан тушаалд нь томилов.

“Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах хөтөлбөр”-ийг газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/142 тоот тушаалаар батлуулж, хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын ажиллах тав тухтай, тохилог орчныг бүрдүүлэх зорилгоор байрны засвар тохижилтын ажил хийх, тавилга, техник хэрэгсэл худалдан авахад нийт 739,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Цайны өрөөг иж бүрэн тохижуулах, Эх үрсийн баяраар албан хаагчдын 0-16 насны 90 хүүхдэд бэлэг өгөх, Спортын хамтлаг байгуулж дэмжиж ажиллуулах, гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 7 албан хаагчид тус бүр 100.000 төгрөгийн тэтгэмж, 3-7 хоногийн цалинтай чөлөө, ар гэрт нь гачигдал тохиолдсон 4 албан хаагчид тус бүр 300 000 төгрөгийн буцалтгүй тусламж, цалинтай чөлөөг газрын даргын тушаалаар тухай бүр олгуулж, нийт 1 сая 900 мянган төгрөгийг тэтгэмж, тусламжинд зарцуулсан.

Төрийн үйлчилгээний 8 албан хаагчтай Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажил үүргийг гүйцэтгүүлж байна. “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах тухай “ Засгийн газрын

2012 оны 37 дугаар тогтоолд Төрийн албаны ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод монгол хэл бичгийн мэдлэгийн түвшинг харгалзах ур чадварын шаардлагыг нэмж тусгахыг Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосны дагуу албан хаагчдад тавигдах чухал шаардлагатай ур чадварт “Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүй, албан хэрэг хөтлөлтийн стандартын мэдлэг, ур чадвартай байх” гэсэн шаардлагыг тусгаж шинэчлэн 2013 оны 06 дугаар сарын 11-нд батлуулсныг одоо мөрдөж байна. Төрийн албаны шалгалт өгч тэнцсэн 8 албан хаагчийг Тангараг өргүүлэв.

Цалин нэмэгдлийг шинэчлэн тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 21, зэрэг дэвийн нэмэгдлийг 9, докторын зэргийн нэмэгдлийг 2, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 3, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 1 ажилтанд тус тус олгож байна.

Худалдан авах ажиллагааны газрын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Шадар сайдаар батлуулан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд ханган ажиллаж байна. Мөн Төсвийн шууд захирагч менежерүүдтэй, менежерүүд төрийн албан хаагчидтай хуулийн хугацаанд үр дүнгийн гэрээ байгуулж хагас, бүтэн жилээр дүгнэж ажиллахаар төлөвлөсөн ба 2013 оны эхний хагас жил болон жилийн эцсийн үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагаа мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр А, В, С үнэлгээ авсан албан хаагчдад үндсэн цалингийн 30-100 хувийн урамшуулал олгосон.

Албан хаагчдын хөдөлмөрийн амжилтыг үнэлж, ЗГ-ын “Хүндэт өргөмжлөл” шагнал, Хөдөлмөрийн хүндэт медаль, яамдын Хүндэт жуух, МЗХ-ны шагналуудаар нийт 20 хүнийг шагнуулсан ба 9 албан хаагч сануулах, 4 албан хаагч цалин бууруулах сахилгын шийтгэл хүлээсэн.

Байгууллагын албан хаагчдын сургалтын хэрэгцээ, бусад төрийн байгууллагуудын туршлагыг судалсны үндсэн дээр 7 зүйл бүхий “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан, газрын даргын 2013 оны 10-р сарын 18-ны өдрийн Б/104 тоот тушаалаар батлуулсан. Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2013 онд Дэлхийн банкны “Худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх” төслийн санхүүжилтээр 21 ажилтан гадаадын 7 оронд сургалтанд хамрагдаж, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлсэн. 2013 оны байдлаар ЗҮХААХ-ийн дарга М.Угтахбаярыг Удирдлагын Академийн Төрийн удирдлагын гарагийн ангид, ЗУХ-ийн мэргэжилтэн Н.Энхбатыг ХБНГерман улсын Засгийн газрын тэтгэлэгт магистрийн сургалтанд хамруулаад байна.

#### Байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр

Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2013 оны 02-р сарын 05-нд “Хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн гаргах”, 05 сарын 02-нд “Авилгын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилт”, 2013 оны 04-р сарын 03-нд “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, 09 дүгээр сарын 27-нд “Үнэлгээний хорооны гишүүдийн хариуцлага ба ашиг сонирхлын зөрчил”, 11 дүгээр сарын 01-нд “Мэдээллийн ил тод байдал”, 12 дугаар сарын 11-нд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хуулийн хэрэгжилтийг хангах нь” сэдвээр нийт 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 345 гаруй албан хаагчийг хамруулсан.

ЗГХЭГ-ын 2013 оны 03 сарын 13-ны өдрийн х/92 тоот албан бичгийн дагуу “Эбльсофт” ХХК ablecloud е-оффисын программыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд 2013 оны 05, 11-р сард 2 удаа “Эбльсофт” ХХК-ны холбогдох мэргэжитнийг урьж, ablecloud е-оффисын програмыг байгууллагын дотоод үйл ажиллагаанд хэрхэн ашиглах



талаарх сургалтыг газрын нийт албан хаагчдад зориулан зохион байгуулж, тус программыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт, ирсэн, явсан албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.

Мөн түүнчлэн Архивын ерөнхий газар, Төрийн албаны зөвлөл, “Мэргэн түшээ” ТББ, Цөмийн энергийн газраас зохион байгуулсан сургалт, Сангийн яам, японы Жайка ОУ-ын байгууллагын хамтарсан “Дотоод аудитын ойлголт”, “Эрсдлийн удирдлага ба эрсдэлийн удирдлагын тогтолоо” сургалтад байгууллагын нийт албан хаагчдыг ажлын байран дээр нь хамруулсан нь тэдний мэдлэг, мэдээллийн хүрээг өргөжүүлсэн ажил болов.

#### Дүрэм, журам, стандарт боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр

“Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын төсөлд санал өгч, Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн бөгөөд уг журам Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсаныг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

“Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам”-ийн төслийг боловсруулан нийт аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны нэгжүүдэд хүргүүлсэн.

“Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах” журмын төсөлд санал өгсөн бөгөөд Сангийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 11 өдрийн 07 дугаар тушаалаар уг журам батлагдсаныг мөн мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын дотоодод “Худалдан авах ажиллагааны газрын дотоод журам”, “Ёс зүйн хорооны журам”, “Ес зүйн дүрэм”, “Цахим худалдан авах ажиллагааны түр журам”, “Худалдан авах ажиллагааны газарт нэвтрэх журам”, “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд урамшуулал олгох гэрээ”, “Даргын зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус 2013 онд боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна.

Төрийн бус байгууллагын төлөөлөлд урамшуулал олгох, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 26 төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой гэрээ байгуулан ажилласан бөгөөд тэдгээрийн төлөөлөл давхардсан тоогоор 128 хүн 389 үнэлгээний хорооны бүрэлдхүүнд ажилласан байна.

Мөн газрын хэмжээнд дагаж мөрдөх Албан хэрэг хөтлөлт, архивын журмын төслийг боловсруулан батлуулахаар бэлтгэж байна.

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд нийцүүлэн Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчийн “Ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн хорооны ажиллах журам”-ыг шинэчлэн баталж, Ёс зүйн хороо байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийт албан хаагчдын ажлын байр, албан тушаалын тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллах талаар тодорхой зүйл заалтыг тусган шинэчлэн баталсан бөгөөд 2013 оны жилийн эцсийн байдлаар тус хороогоор ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан аливаа асуудал шийдвэрлэгдээгүй. Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй эсэхэд үйлчлүүлэгч, иргэд, хөндлөнгийн хяналтыг бий болгох зорилгоор

байгууллагын [www.procurement.gov.mn](http://www.procurement.gov.mn) вэб сайтад байршуулсан-оффис програмаар бүх албан хаагчдад танилцуулсан.

Худалдан авах ажиллагааны газрын “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, “Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-үүдийг шинээр батлан хэрэгжүүлж эхлэв.

Сангийн яамнаас боловсруулж, Засгийн газрын 2013 оны 89 дүгээр тогтоолоор батлуулсан “Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т тус газраас зохион байгуулах арга хэмжээний 3 зорилтыг тусгуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1. Цахим худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, худалдан авах ажиллагаанд оролцогч бүх талуудын 30-аас доошгүй хувийг сургалтанд хамруулсан байх зорилтын хүрээнд, ХААГ-т 20 хүний багтаамжтай цахим сургалтын лаборатори танхимыг байгуулан тохижуулж, цахим сургалтыг долоо хоногт 2 удаа тогтмол зохион байгуулж, нийт 1400 иргэд, ААН-ийн төлөөллийг хамруулсан. Ховд, Орхон аймгуудад зохион байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтын хөтөлбөрт цахим худалдан авах ажиллагааны системийн танилцуулгыг оруулж, тус системийн талаар сургалт зохион байгуулсан.

“Цахим худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах” талаарх сургалтыг орон нутгийн худалдан авах ажиллагааны албадын ажилтнуудад 7 удаа зохион байгуулж, орон нутгийн 31 нэгжийн 447 албан хаагчийг хамруулсан. Үүнд:

- 1.1. 2013 онд Нийслэлд 3 удаа зохион байгуулж, нийт 60 албан хаагч,
- 1.2. 2013 оны 12 сарын 03-нд Хэнтий, Төв аймаг, нийслэлийн 9 дүүргийн 20 албан хаагч,
- 1.3. 2013 оны 12 сарын 11-нд орон нутгийн 31 нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн, нийт 75 албан хаагч,
- 1.4. 2013 оны 12 сарын 13-нд Орхон, Увс аймгийн Худалдан авах ажиллагааны албаны 8 албан хаагчийг тус тус хамруулсан.
- 1.5. Мөн "АРД ТҮМЭН ТА ХААН" форумын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар нь "Мерси Кор" ОУБ-тай хамтран Цахим худалдан авах ажиллагааны талаарх сургалтыг Blackboard системийг ашиглан орон зайн хамааралгүйгээр зохион байгуулж, 15 аймгийн Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн, иргэдийн төлөөлөгч, тендерт оролцогч 284 хүнийг хамрууллаа.

2. Орон нутгийн Худалдан авах ажиллагааны нэгжүүдийн ажилтнуудыг худалдан авах ажиллагааны сургалтанд 100 хувь хамруулах ажлын хүрээнд, 2013 онд Орон нутгийн 31 нэгжид “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг Сангийн яам, орон нутгийн захиргааны байгууллага, худалдан авах ажиллагааны нэгжүүд, Мерси кор ОУБ, Тогтвортой амьжиргаа төслийн байгууллага, сургалтын төвүүдтэй хамтран аймаг тус бүрт 1-3 удаа, нийт 78 удаа зохион байгуулж, орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчид, Худалдан авах ажиллагааны нэгжийн албан хаагчид, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл нийт 5000 гаруй хүнийг хамруулан чадавхижуулсан ба орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийн бүх албан хаагчид мэргэшсэн албан хаагчийн АЗ гэрчилгээтэй болсон нь худалдан авах ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулах чадавхитай болсныг илэрхийлж байна.

3. Худалдан авах ажиллагааны газрын дэргэд “Сургалт, судалгааны төв” байгуулах ажлын хүрээнд, тус төвийн ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах зардлыг 2014 оны улсын төсөвт суулгуулах саналаа Шадар сайдын ажлын албанд, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээг боловсруулах жишиг матриц”-д “Сургалт, судалгааны төв байгуулах” талаарх саналаа тусган ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн боловч дэмжигдээгүй.


Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, ил тод байдлыг хангах чиглэлээр

Байгууллагын 1 дүгээр давхарт дэвшилтэт технологи бүхий хүлээлгийн танхим, нэг цэгийн үйлчилгээний танхим, тендерийн нээлт, мэдээллийн танхим, үнэлгээний хорооны хурлын өрөөг ашиглалтанд оруулж иргэд, аж ахуйн нэгжүүдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүргэн үйлчилж байна.

Гаднаас ирсэн үйлчлүүлэгчдийг угтан авч цахим бүртгэл хөтлөн бүртгэж архив үүсгэн ажилласны үр дүнд сүүлийн хагас жилийн үйлчлүүлэгчдийн нэгдсэн мэдээлэлтэй болсон. Угтах үйлчилгээтэй холбоотой ямар нэг гомдол санал ирээгүй. Цаашид үйлчилгээний соёлыг улам сайжруулж үйлчлүүлэгчдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээг хүргэж ажиллана. Үйлчлүүлэгчдийн утасны дуудлагыг хүлээн авч тодорхой холбогдох ажилтан хэлтэстэй холбож өгдөг. Үүний үр дүнд үйлчлүүлэгч анхан шатны мэдээллийг түргэн шуурхай авсны тусламжтайгаар түргэн шуурхай үйлчлүүлдэг болсон.



*Хүлээлгийн танхим*



*Хүлээлгийн танхим*



*Нэг цэгийн үйлчилгээний танхим*



Нэг цэгийн үйлчилгээний танхим



Тендерийн нээлтийн өрөө

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд төлбөр, тооцоог нэг цэгээс хийх боломж олгож, банкны үйлчилгээг үзүүлэхээр арилжааны 13 банкинд сонгон шалгаруулалтад оролцохыг урьсан тендерийн урилга хүргүүлж, сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж, шалгарсан Төрийн банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Нэг цэгийн үйлчилгээний төвд төлбөр, тооцооны үйлчилгээ үзүүлэх банкныг сонгон сонгон шалгаруулсан тайлан мэдээллийг Төрийн өмчийн хороо, АТГ-т албан бичгээр тус тус хүргүүлэн мэдэгдэв.

“Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг 3-р сараас нээн ажиллуулж, тендерт оролцогчид мэдээллийг нэг цэгээс шуурхай хүлээн авч, тэдэнд чирэгдэлгүй үйлчлэх боломж, таатай нөхцлийг бүрдүүлэв. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр нийт 10 сарын хугацаанд /3-12-р сард/ 20363 иргэн, ААН, байгууллагад үйлчилснээс 8013 иргэн, аж ахуй нэгжид худалдан авах ажиллагааны талаарх хууль эрх зүйн мэдээлэл, шаардлагатай зөвлөгөө өгч, 3804 аж ахуй нэгж, байгууллагад тендерийн баримт бичиг худалдаж, 8546 ААН, байгууллагад тендертэй холбоотой тодруулга, мэдэгдэл, саналын урилга хүргүүлж, ажиллав.

Зураг 3.


“Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйлчилгээ, 2013 он





Зураг 4.

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр үйлчлүүлэгчдийн тоо, 2013 он



Тендерийн нээлтийн танхимыг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож тохижуулсан нь нээлтэд оролцогч компани, ААН-үүд, ирүүлсэн материалын бүрэн бүтэн, шаардлага хангасан байдлыг дэлгэцэнд шууд харуулж, ил тод зарлаж, аливаа гомдол, маргаан гаргахгүй байх бололцоо бүрдлээ.



*Тендерийн нээлтийн танхим*



*Тендерийн нээлт*


Сургалтын заал, уулзалтын танхим, үнэлгээний хорооны хурлын өрөөнд батлагдсан цагийн хуваарийн дагуу жилийн турш үнэлгээний хорооны хурлуудыг хуралдуулж хэвшил болгосон. Үнэлгээний хорооны хурал дунджаар нийт 940 удаа хуралдсан байна. Үүнд: АХААХ – 287, БХААХ – 248, ЗҮХААХ – 264, ЦХААХ – 78.

Жилийн дүнгээр давхардсан тоогоор 523 тендерийн нээлт болсон. Үүнд: АХААХ – 175, БХААХ – 144, ЗҮХААХ – 133, ЦХААХ – 71 нээлт болсон байна.

Хурлын танхим, сургалтын зааланд дунджаар 95 хурал, сургалт явагдсан. Үүнээс, сургалт - 32, уулзалт - 15, агентлагийн шуурхай – 48 болсныг угтах үйлчилгээний хүрээнд зохицуулан зохион байгуулалтаар ханган ажиллав.

Шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Тендерийнбудлиан, авлига, хээлхахуулийгхалахзорилгоортөсвийнхөрөнгөөрбараа, үйлчилгээхудалданавахүйлажиллагааг 100 хувьонлайнхэлбэртшилжүүлж, иргэд, олоннийтийнхяналтандор илтодявуулна” гэсэн зорилт дэвшүүлсэний хүрээнд “Худалдан

авах ажиллагааны хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, сургалт, судалгааны төв байгуулах”, “Монгол улсад цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх төсөл”-ийн II үе шатыг эхлүүлэх зорилгоор 2014–2016 онд хэрэгжүүлэх нийт 3.5тэрбум төсөвт өртөг бүхий Худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийг тайлант хугацаанд боловсруулан Шадар сайдын ажлын алба болон Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.



Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл олж авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг хангахад анхаарч, байгууллагын вэб хуудсыг боловсруулж ашилалтанд оруулсан ба Үндэсний дата төв, Датаком ХХК-иас [www.procurement.gov.mn](http://www.procurement.gov.mn), [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) домэйн нэрүүд дээр байгууллагын вэб хуудсыг байршуулан ажиллуулж байгаа бөгөөд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон

тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар,авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон бусад мэдээллийг байршууллаа.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилж, ил тод байдлын самбарыг ажиллуулан Авлигатай тэмцэх газрын вэб хуудсыг байгууллагын вэб хуудсанд холбож мэдээлэл, сурталчилгааг шуурхай түгээх боломжийг бүрдүүлсэн.

Мөн байгууллагын 2012 оны үйл ажиллагааны тайлан, бүтэц бүрэлдэхүүн, гүйцэтгэх чиг үүрэг, зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хэрэгжилт, зохион байгуулсан худалдан авах ажиллагааны явц, үр дүн, 2012 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитийнтайлан, дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд байрлуулан олон нийтэд мэдээлж, санхүүгийн ил тод байдлыг бүрэн ханган ажилласан. Хөрөнгө оруулалтын хүрээнд зарцуулагдаагүй үлдсэн төсвийн үлдэгдэлгүй байна.

Худалдан авах ажиллагаанд оролцогч олон улсын байгууллага иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсыг англи хэл дээр болгох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.





## ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭНАРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр:

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хэрэгжилтэд гарч буй хүндрэл, бэрхшээл, зөрчлийг арилгах, худалдан авах ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, захиалагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоох, тайлагнах, хяналт тавих ажиллагааг оновчтой зохион байгуулах шаардлагыг харгалзан тус хуулийн 5 зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2013-06-04-ний өдрийн 94 дүгээр захирамжаар Шадар сайд Д.Тэрбишдагваар ахлуулан 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Уг ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа, үйл ажиллагаа хариуцсан Дэд дарга Ж.Булгантамир томилогдсон бөгөөд Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргал, тус гарын Хуулийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд холбогдох бусад албан тушаалтнууд хуулийн төслийн боловсруулалт дээр Сангийн яамтай хамтран ажиллаж, боловсруулан Монгол Улсын Шадар Сайдад танилцуулан саналыг нь тусгаж, өгсөн чиглэлийн дагуу ЭЗХЯ-нд санал авахаар хүргүүлээд байна. Иргэд, олон нийтийн саналыг хуулийн төсөлд авах, тэднээс өгсөн саналыг тусгах зорилгоор газрын [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) цахим хуудсанд хуулийн төслийг тавин санал авсан.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны алба байгуулах тухай Монгол улсын Засгийн газрын 144 дүгээр тогтоолыг батлуулсанаар нийслэл, 21 аймагт Худалдан авах ажиллагааны нэгжүүд байгуулагдсантай холбоотойгоор худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, зөвлөмж, үлгэрчилсэн дүрэм, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг хүргүүлэн эрх зүйн зөвлөмжөөр ханган ажиллав. 2013 онд орон нутагт худалдан авах ажиллагааны 31 нэгж байгуулагдан, 146 албан хаагчтайгаар 2013 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллав. 2013 оны 12 сарын 10-ний байдлаар орон нутгийн 31 нэгжид 538 876,39 /тэр бум/ төгрөгний 3012 төсөл арга хэмжээ 98 хувьтай хэрэгжсэн байна.

Сангийн яамнаас зохион байгуулсан Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах сургалт, Мерси кор Олонулсын байгууллага, Авилгатай тэмцэх газартай хамтран “Монгол улсын бүх сумдын нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагуудад зориулсан сургалт”-д худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийн албан хаагчдыг хамруулан, Худалдан авах ажиллагааны газраас орон нутгийн удирдлагуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар мэдээлэл зөвлөгөө өгч хамтран ажиллав.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө зэргийг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 90,7 %-тай байна.

Тайлант хугацаанд нийт 47 албан хаагчаас 2012 оны “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг гаргуулан авч, хуулийн хугацаанд багтаан холбогдох газарт хүргүүлсэнээс гадна нийтийн албанд шинээр ажилд томилогдохоор нэр дэвшсэн 17 албан хаагчийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг авч, холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулсны үндсэн дээр нийтийн албанд томилсон. Мөн хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт гарсан 21 албан хаагч болон 2013 онд нийтийн албанд шинээр томилогдсон 53 албан хаагчийн ХАСХОМ-ыг гаргуулан мэдээллийн санд оруулсан.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн -ийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсгийн 26-д заасны дагуу Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын зохион байгуулах 387 төсөл, арга хэмжээг зохион байгуулах 217 үнэлгээний хорооны 854 (давхардсан тоогоор) гишүүний ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг тухай бүр гаргуулан авч, цахим системд бүртгэн оруулав.

2013 оны жилийн эцсийн байдлаар Авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд тус газрын хэмжээнд зөрчил тогтоогдоогүй байна.

2013 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 11-нд нийт 2 удаа худалдан авах ажиллагааны нэгжийн удирдах ажилтнуудад зориулсан сургалт семинарын үеэр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгсөн бөгөөд орон нутагт Худалдан авах ажиллагааны нэгж байгуулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж хүргүүлэн, гарын авлага, холбогдох материалаар ханган ажиллав.

Тус байгууллагын удирдлагууд албан хаагчдаа манлайлан үлгэрлэж, авлигаас



*Илэрхийлэл өргөж байгаа нь АХА тэмцээн - уралдаан*

ангид байх хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэх арга хэмжээг “Авлигын эсрэг хамтдаа” уриан дор 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсан нь төрийн байгууллагуудад болон албан хаагчдад үлгэр жишээ болохуйц ажил боллоо. Мөн албан хаагчдын хууль тогтоомжийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэхэд чиглүүлж, АХА хөгжөөнт тэмцээн уралдааныг АТГ-тай хамтран зохион байгуулав.

Худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод, шударга байх зарчмын хэрэгжилтийг хангах талаар төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд:

- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчин

бүрдүүлэх, шударга өрсөлдөөнийг бий болгох, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж түүний хэрэгжилтийг хуулийн хүрээнд ханган ажиллав.

- Авлигатай тэмцэх газартай Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж Авлигатай тэмцэх газар, Шадар сайдын хамтран ажиллах санамж бичгийг албажуулсан.
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.
- Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн ТББ-тай хамтран ажиллаж, Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааны ажилд нь дэмжлэг үзүүлэв.

#### Худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэлээр

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтанд батлагдсан 399 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тайлант оны эхнээс ажиллах хугацаанд нийт 8 удаагийн тогтоолоор нийт 69 төсөл, арга хэмжээ анхын жагсаалтаас хасагдаж, 330 төсөл, арга хэмжээ (611 багц)-ний тендер шалгаруулалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – ХААГ-т зохион байгуулж байсан боловч 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар Монгол Улсын 2013 оны төсвийн тодотгол батлагдсанаар 198 хуулийн дугаар бүхий 413 багц төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ХААГ-аас хэрэгжүүлэхээр тодотгон баталсан ба тэдгээрийн гүйцэтгэлийн явцыг 12 дугаар сарын 18-ны байдлаар дүгнэвэл, 386 төсөл, арга хэмжээ буюу 93,5 % нь бүрэн хэрэгжсэн, 24 төсөл, арга хэмжээ буюу 5,8 % нь хэрэгжих шатанд байна. Зураг, төсөв ирээгүй болон дутуугаас шалтгаалан 3 ажил хэрэгжих боломжгүй болсон нь нийт ажлын 0,7 %-ийг эзэлж байна.

2013 онд 169 арга хэмжээнд нийт 351,9 тэрбум төгрөгийн 330 гэрээ бүртгэгдсэн ба төсвийн үнэ (366.9 тэрбум төгрөг)-ээс 14,9 тэрбум төгрөгийн хэмнэлт гарав.

Зохион байгуулсан худалдан авах ажиллагааг ажил, бараа, зөвлөх үйлчилгээний чиглэлээр дор тодруулан дүгнэв.

#### **1. Ажил худалдан авах ажиллагаа:**

Монгол Улсын Засгийн тогтоолоор 2012 оны 131 дүгээр тогтоолоор батлагдсан төсөл арга хэмжээнээс АХААХ-т хамаарах 255 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Үүнээс: Төсвийн тодотголоор хасагдсан ажил 113, Засгийн газрын тогтоолоор хасагдсан ажил 58, Үлдсэн ажил 84 /Задаргаагаар 141/. Үүнээс: Гэрээ байгуулсан, мэдэгдэл хүргүүлсэн ажил 80 /134/, дахин зарласан, зарласан ажил 3 /4/, Зураг төсөл дутуу ирүүлсэн 1 /3/ ажил байна.

Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн ажлууд:

- Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх/,
- Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх/,

- 10 аймгийн төвийн инженерийн байгууламж шугам сүлжээг шинэчлэх, шинээр байгуулах /Архангай, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон/ ажлын Багц 1: Хонгор-100 орон сууцны инженерийн шугам сүлжээ /Баянхонгор/.

Дахин зарласан, зарласан ажлууд:

- Аймгийн нисэх буудлын аэродромын өргөтгөл, хүчитгэлийн ажил, 2 дугаар үе шат /Хөвсгөл/,

- Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэл, засварын цех /Улаанбаатар/ ажлын 2 багц,

- Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээ /Төв, Хөшгийн хөндий/.

Зураг төсөл дутуу ирүүлсэн ажлууд:

- БНЧехУлсын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх нөхцлөөр хэрэгжүүлэх "Евро Эко Төгөл" төсөл, /Орхон/,

Эрх шилжиж ирсэнажлууд:

Салбарыняамдаасэрхшилжижирсэн 12 ажлаасгэрээбайгуулсан9, гэрээбайгуулахэрхолгохтухаймэдэгдэлхүргүүлсэн1, шууд гэрээ байгуулах шатандаа байгаа 1, тендерзарласан 1зэрэг дарааажлуудбайна.

Цахим тендер шалгаруулалтын журмын дагуу 2013 онд нийт 84 ажлын тендерийг зарласан. Үүнээс төсвийн тодотголоор үлдсэн 141 /задаргаар/ ажлаас 31 буюу 22 хувийг цахим тендер шалгаруулалтын журмын дагуу зарласан.

## 2. Бараа худалдан авах ажиллагаа:

2013 онд 264 бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах төсөл, арга хэмжээг зохион байгуулахаас 14 төсөл арга хэмжээний эрх шилжиж, 61 төсөл, арга хэмжээ төсвийн тодотголоор хасагдсан. Хэрэгжүүлж дууссан 169 төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан 143, гэрээ байгуулах шатандаа 25 төсөл, арга хэмжээ байна. Бараа худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 92 %-тай байна.

Хэрэгжүүлж дуусаагүй 21(хуулийн дугаараар7) төсөл байгаа ба үүнээс үнэлгээ хийгдэж буй 1, тендер зарласан нээгээгүй байгаа 3, дахин зарлах 3, шууд гэрээ байгуулах 14 төсөл арга хэмжээнд 2 удаа зарлаад сонирхогч этгээд оролцоогүй улмаас хүчингүй болж шууд гэрээ байгуулах шийдвэр гарсан боловч мөн адил сонирхогч этгээд оролцоогүй. Иймээс нийт бараа худалдан авах ажиллагаанаас 8 хувийг хэрэгжүүлээгүй байна.

2013 онд зохион байгуулагдах бараа худалдан авах ажиллагааны 20 гаруй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулсан.

## 3. Зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагаа:

2013 онд хуулийн дугаараар зөвлөх үйлчилгээний 72 төсөл, арга хэмжээ буюу 147 багцын ажлыг хэрэгжүүлэхээр батлагдсан. Үүнээс Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийн дугаараар 22 төсөл, арга хэмжээ буюу 45 багц ажил хасагдсан болно.

Нийт хуулийн дугаараар зөвлөх үйлчилгээний 50 төсөл, арга хэмжээ буюу 102 багц ажил хэрэгжүүлэхээс бажлыг салбарын яамдын хүсэлтийн дагуу тус яамд нь хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн. Үлдсэн 96 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дуусч, гэрээ байгуулсан ба гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүргүүлсэн бөгөөд ажлын хэрэгжилт 94.1 %-тай байна. Түүнчлэн Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газрын бүх нийтийн үүргийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хөдөө орон нутгийн иргэдэд мэдээлэл, харилцаа холбооны мэдлэг олгох” зөвлөх үйлчилгээний тендерийг тус байгууллагаас эрх шилжиж ирсний дагуу тендерийг зарласан, нийт 5 зөвлөх үйлчилгээний ажил буюу 5.9 % нь хэрэгжилтийн шатандаа явж байгаа бөгөөд гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг хэрэгжүүлж, дуусгахаар ажиллаж байна.

Зөвлөх үйлчилгээний нийт 8 тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4. дэх заалтын дагуу тус газраас 2013 онд зохион байгуулж хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах яам, агентлагын 266, албан хаагч, төрийн бус байгууллагын 126 ажилтнаас бүрдсэн мэдээллийн санг үүсгэж, 387 төсөл, арга хэмжээг зохион байгуулах 217 үнэлгээний хороонд давхардсан тоогоор нийт 854 захиалагч болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулав. Мөн шаардлагатай гэж үзсэн зарим үнэлгээний хороодод Тагнуулын ерөнхий газрын төлөөллийг оруулан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад Зураг төсөв, мэдээлэл ирүүлэх тухай Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт ХААГ-аас нийт 171 албан бичгийг хүргүүлж, төлөвлөгөөт худалдан авалтыг шуурхай зохион байгуулах арга хэмжээг жилийн турш авч хэрэгжүүлсэн. Явуулсан бичгийг захиалагчийн нэрээр харуулбал,

- |                |                     |                 |
|----------------|---------------------|-----------------|
| 1. СЯ – 6,     | 12. ХАХНХЯ - 6,     | 23. НАЗГ - 1,   |
| 2. ЭХЯ – 9,    | 13. БОНХЯ – 9,      | 24. ЭХХТ – 1,   |
| 3. УУЯ – 6,    | 14. БХЯ – 6,        | 25. ШСАА – 1,   |
| 4. ЗТЯ – 16,   | 15. ГХЯ – 5,        | 26. МШХХТГ – 2, |
| 5. БХБЯ - 20,  | 16. ХЗЯ – 6,        | 27. ОБЕГ – 1,   |
| 6. ЭЗХЯ – 9    | 17. НЗД – 1         | 28. МХЕГ – 1,   |
| 7. БШУЯ – 11,  | 18. БХТ – 1,        | 29. ШЕЗ – 1,    |
| 8. ХЯ – 9,     | 19. ГХГЗЗГ – 1,     | 30. УДШ – 1,    |
| 9. ССАЖЯ – 10, | 20. ГЕГ – 2,        | 31. АТГ – 1,    |
| 10. ЭМЯ - 11,  | 21. ШӨХТГ – 1,      | 32. НХОГ – 1,   |
| 11. ҮХААЯ – 8, | 22. УЕПрокурор – 2, | 33. СХЗГ – 3.   |

#### Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд



“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т тусгагдсан “Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулж, захиалагч нь шийдвэрлэдэг өнөөгийн тендерийн тогтолцоог өөрчилж гүйцэтгэгч нь шийдвэрлэдэг



болгох” заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.

ХААГ-т 20 хүний багтаамжтай цахим сургалтын лаборатори танхимыг байгуулан тохижуулж, цахим сургалтыг долоо хоногт 2 удаа тогтмол зохион байгуулж, нийт 1400 иргэд, ААН-ийн төлөөллийг хамруулсан. 2013 оны 02 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд Орхон аймагт, 2013 оны 03 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Ховд аймагт зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтын хөтөлбөрт цахим худалдан авах ажиллагааны системийн танилцуулгыг оруулж, тус системийн талаар сургалт зохион байгуулсан.

“Цахим худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах” талаарх сургалтыг орон нутгийн худалдан авах ажиллагааны албадын ажилтнуудад 7 удаа зохион байгуулж, орон нутгийн 31 нэгжийн 447 албан хаагчийг хамруулсан. Үүнд:

- 1.1. 2013 онд Нийслэлд 3 удаа зохион байгуулж, нийт 60 албан хаагч,
- 1.2. 2013 оны 12 сарын 03-нд Хэнтий, Төв аймаг, нийслэлийн 9 дүүргийн 20 албан хаагч,
- 1.3. 2013 оны 12 сарын 11-нд орон нутгийн 31 нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн, нийт 75 албан хаагч,
- 1.4. 2013 оны 12 сарын 13-нд Орхон, Увс аймгийн Худалдан авах ажиллагааны албаны 8 албан хаагчийг тус тус хамруулсан.
- 1.5. Мөн "АРД ТҮМЭН ТА ХААН" форумын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар нь "Мерси Кор" ОУБ-тай хамтран Цахим худалдан авах ажиллагааны талаарх сургалтыг Blackboard системийг ашиглан орон зай, цаг хугацааны хамааралгүйгээр зохион байгуулж, 15 аймгийн Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн, иргэдийн төлөөлөгч, тендерт оролцогч 284 хүнийг хамрууллаа.



Цахим гарын үсэг PKI олгох өдөрлөгийг 2013 оны 01 дүгээр сар 25-ны өдөр ШУТИС-ын хурлын зааланд зохион байгуулан 130 иргэнд сургалт хийж, 2013 оны 03 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Зам тээврийн яамнаас Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулсан “Road expo-2013” Олон улсын үзэсгэлэнд оролцож, 200 иргэнд, 2013 оны 05 дугаар сарын 17-21-ний хооронд Мишээл expo төвд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны

газраас зохион байгуулсан ICT Expo-2013 өдөрлөгт оролцож, 450 иргэнд худалдан авах ажиллагаа болон цахим худалдан авалтын талаарх мэдээллийг тус тус хүргэв. Цахим худалдан авах ажиллагааны системийн танилцуулга, гарын авлагыг цахим хэлбэрээр бэлтгэн 2100 ширхэг CD-г иргэд, олон нийтэд үнэ төлбөргүйгээр тараан сурталчилсан ба уг системийг иргэд ойлгоход хялбар болгох зорилгоор заавар, гарын авлагыг видео хэлбэрээр бэлтгэн /www.youtube.com/ вэб сайт дээр байршуулан 2200 гаруй иргэд, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр ханган ажилласан.

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн бэлтгэсэн “Тендерийн хөтөч I”, “Тендерийн хөтөч II”, Eagle Телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгүүдээр цахим худалдан



авах ажиллагааны системийн талаар сурталчилсан. Түүнчлэн телевизийн ярилцлага 8 удаа, сонины ярилцлага 5 удаа өгсөн.

Цахим худалдан авах ажиллагааны MEPS системд нийт 487 аж ахуйн нэгжүүдийг бүртгэн цахим системийн хувийн нууцлалын кодыг олгосон нь нийт тендерт оролцсон **695** ажахуйннэгжийн **70,1%-ийг эзэлж** байна.

2013 онд Цахим худалдан авах ажиллагааны дээрх системээр давхардсан тоогоор нийт 167 төсөл, арга хэмжээний худалдан авалт зохион байгуулагдсан. ХААГ-ын 2013 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээнээс 43 төсөл, арга хэмжээний 98 багц ажлын худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь нийт төсөл, арга хэмжээний 22,2 %-ийг эзэлж байна. Нэг тендерт 4-5 оролцогч оролцсон ба давхардсан тоогоор 724 ААН цахим худалдан авах ажиллагаанд оролцсон байна.

Цахим худалдан авах ажиллагааны системийн мэдээлэл солилцоог сайжруулах ажлын хүрээнд Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Капитал банк, Төрийн банк, Голомт банк, Хас банк, Хаан банкуудтай цахим тендерийн баталгаа гаргах системийн холболтуудыг хийж гүйцэтгэсэн. 4,7 тэрбум төгрөгийн цахим тендерийн баталгааг дээрх нэр бүхий банкаас цахим систем ашиглан гаргасан байна. Татварын ерөнхий газрын мэдээллийн системийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхитай холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр авч байгаа боловч системтэй шууд холболт хийгдээгүй байна.

Цахим дэлгүүр (e-Catalog, e-Shopping Mall) ажиллуулах заавар, төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын 50 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан ба Сангийн яам, Дэлхийн банкны төлөөллүүдтэй ерөнхий гэрээний загвар, төслийн талаар уулзалт зохион байгуулан бэлтгэл ажлыг ханган ажиллав.

Байгууллагын худалдан авах ажиллагааны явцын хяналтын системийг нэвтрүүлж, тус газраас 2013 онд хэрэгжүүлсэн 193 төсөл, арга хэмжээний 437 багц ажлын худалдан авах ажиллагааны явцын мэдээллийн санг бүрдүүлэн, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллээр иргэд, олон нийтийг тогтмол ханган ажиллаж байна.

## ГУРАВ. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

### Гадаад хамтын ажиллагааны хүрээнд



Агентлагийн үйл ажиллагааг олон улсын стандартад ойртуулж ажиллах, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд байгууллагын гадаад харилцааны бодлогыг чиглүүлэн ажиллаж байна.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, КОЙКА олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар, Мерси-Кор ОУБ, “Хөдөө аж ахуйг дэмжих олон улсын сан”, Азийн сан, Европын сэргээн босголт, хөгжлийн банк

зэрэг олон улсын байгууллагуудтай Засаглалын ил тод байдал, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, цахим худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах, олон улсын зөвлөх, мэргэжилтэн ажиллуулах, өндөр хөгжилтэй оронд албан хаагчдаа сургалтанд хамруулах, туршлага судлах гэх мэт олон талаар хамтран ажилласан.

БНСУ-ын КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Монгол улсад цахим худалдан авах ажиллагааны систем нэвтрүүлэх” төслийн гүйцэтгэгч Самсунг СДС компани төслийн багийг урьж, 2013 оны 02 дугаар сарын 18 өдрөөс 2013 оны 03 дугаар сарын 15-ны хооронд ажиллуулсан ба ажиллах хугацаанд цахим тендер шалгаруулалтын систем, цахим каталог систем, цахим дэлгүүр системийн сургалтыг албан хаагчдад зохион байгуулав.

Азийн хөгжлийн банкны шугамаар Монгол улсын цахим худалдан авах ажиллагааны системийг үнэлэх чиглэлээр олонулсын зөвлөх, БНЭУ-ын иргэн Раманатхан Сомасундарам ХААГ-т 10-12 дугаар сард 2 удаагийн ирэлтээр нийт 1 сарын хугацаатай ажилласан. Энэ хугацаанд Монгол улсын цахим худалдан авах ажиллагааны систем([meps.gov.mn](http://meps.gov.mn))-ийг Монгол улсын хуульд хэр нийцэж буйг, мөн Олон улсын хөгжлийн банкнуудын худалдан авах ажиллагааны бодлого, журамд хэр нийцэж буй үнэлж, 2 тайлан гаргаснаас гадна Монгол улсынхувьд цахим худалдан авах ажиллагаандбаримтлах бодлогын эхний сонголтот хувилбарыг танилцуулав.



Монгол-Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан эдийн засаг, худалдааны 7 дугаар хуралдаанд оролцож Бүгд Найрамдах Турк Улсын Худалдан авах ажиллагааны газартай хамтран ажиллах талаар санал солилцож, хуралдааны тэмдэглэлд “Туркийн тал олон улсын хэмжээнд өөрийн хуримтлуулсан туршлагыг онцлон тэмдэглээд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд Монголд зарлагдаж буй олон улсын тендрүүдэд оролцох хүсэлтэй байгаагаа тэмдэглэсэн”.БНТУ-ын Ерөнхий сайд

айлчлалын үеэр Засгийн газар хоорондын хэлэлцээрт худалдан авах ажиллагааны чиглэлээр харилцан туршлага судлах, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах асуудлыг тусгуулахаар төлөвлөн Гадаад харилцааны яаманд саналаа хүргүүлэв.

Азийн хөгжлийн банкны жишиг бичиг баримтын дагуу бараа, ажил, зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар мэдлэг олгож, ОУ-ын сертификат олгох сургалтыг 2013.11.11-15-ны өдрийн хооронд зохион байгуулж, Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, Нийслэл, Дүүргийн худалдан авах ажиллагааны нэгж, албаны нийт 40 мэргэжилтнийг хамруулан



чадавхижуулав.



Худалдан авах ажиллагааны газрын санаачлагаар 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн гурван өдрийн турш олон улсын зөвлөхүүд төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг сайжруулах, жижиг дунд үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авах ажиллагаанд оролцох нөхцөл бололцоог хангах чиглэлээр уулзалт, семинар зохион байгуулж, туршлага солилцож, Европын Холбоо, Европын Сэргээн Босголтын Банк болон НҮБ-ийн Олон Улсын Худалдааны

Хуулийн Эрх зүйн хорооны зөвлөхүүд бүхий Гүрж, Англи, Энэтхэг, Португал зэрэг орны төлөөлөгчид илтгэл тавив. Мөн түүнчлэн Цахим ХАА-ны системийг боловсронгуй болгох, ЖДҮ-ийг ХАА-нд оролцоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2013 оны 12 сарын 05-07-нд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хотноо болсон ОУ-ын уулзалт, семинарт ХААГ-ын дарга 4 албан хаагч оролцов.

2013 онд Дэлхийн банкны “Худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх” төслийн санхүүжилтээр Турк, Дани, БНСУ, Итали, Австри, Филиппин, АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс зэрэг гадаадын 7 оронд Худалдан авах ажиллагааны чиглэлээр богино хугацааны сургалтанд 21 ажилтан хамрагдаж, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлсэн ба нийслэл, 21 аймгийн 2500 гаруй иргэнийг гадаадын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэй зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтанд хамруулсан. Мөн дээр дурдсан төслүүдийн хүрээнд худалдан авах ажиллагааны талаар цуврал зурмал хөдөлгөөнт нэвтрүүлгийн 5 ангийг олон нийтийн хүртээл болгож, хялбар аргаар, тодорхой ойлголтыг олон нийтэд өгөх ажлыг зохион байгуулсан нь үр дүнгээ өгч байна.

Дэлхийн банкинд тавьсан саналын дагуу худалдан авах ажиллагааны олон улсын түвшинд хүргэх, стандартыг нутагшуулах зорилгоор тухайн байгууллагын Зөвлөх 2013 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн манай байгууллагад 3 сарын хугацаатай Худалдан авах ажиллагааны талаар олон улсад мөрдөгдөж буй 18 төрлийн стандартыг хөрвүүлэн Монгол улсад нутагшуулахаар ажиллаж, “Барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны ISO-10845 олон улсын стандарт”-ыг Стандарчлал хэмжил зүйн техникийн Үндэсний хороогоор батлуулсан. Ингэснээр Монгол улсын худалдан авах ажиллагааг анх удаа MNS-10845 олон улсын стандартын дагуу зохион байгуулах боломж бүрдсэн.



*Орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйгээр ханган чадавхижуулах чиглэлээр*

Худалдан авах ажиллагааны газрын төлөөлөл Орхон, Төв аймгийн ХААА-ны үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Нийслэлийн ХААГ, Дархан, Өвөрхангай, Сэлэнгэ, Орхон, Увс, Хэнтий аймгийн ХААА-ны бүрэлдэхүүн Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаатай танилцан харилцан мэдээлэл солилцон мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан.



Нийслэлийн 9 дүүргийн ХААА-ны албан хаагчдыг Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаатай танилцуулан, алба тус бүрийн үйл ажиллагаа, худалдан авах ажлын явцын мэдээллийг сонсон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

2013 оны 05 дугаар сарын 17-21-ны өдрүүдэд Мишээл ехро төвд болсон “ICT Expo-2013” өдөрлөг, 2013 оны 09 сарын 22-27-ний өдрүүдэд Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Ховд, Увс, Сүхбаатар аймгуудын Худалдан авах ажиллагааны алба, Мэргэжлийн хяналтын газрын хамтран зохион байгуулсан “АРД ТҮМЭН ТА-ХААН” өдөрлөгт оролцогчдод ХААГ-т зохион байгуулагдаж буй орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэж хүргүүлсэн.

2013 оны 12 сарын 10-нд МУ-ын ЗГ-аас зохион байгуулсан “Шинэчилж шийдье-222” уулзалт - хэлэлцүүлэг “Шилэн тендер-2014” нэрийн дор тендер тойрсон асуудлаар зохион байгуулагдахад 21 аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга, ахлах мэргэжилтэн нарыг оролцуулсан.



2013 онд Орон нутгийн 31 нэгжид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг Сангийн яам, орон нутгийн захиргааны байгууллага, худалдан авах ажиллагааны нэгжүүд, Мерси кор олон улсын байгууллага, Тогтвортой амжиргаа төслийн байгууллага, сургалтын төвүүдтэй хамтран аймаг тус бүрт 1-3 удаа нийт 78 удаа сургалт зохион байгуулж орон нутгийн төрийн байгууллагын албан хаагчид, Худалдан авах нэгжийн албан хаагчид, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл 5000 гаруй хүн сургалтанд хамрагдаж чадавхижсан байна.



2013 оны 12 сарын 11-ны өдөр Худалдан авах ажиллагааны байгууллагын орон нутгийн нэгжийн удирдах албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг Цахим худалдан авалт хэрхэн зохион байгуулах, Архив, албан хэрэг хөтлөлт, “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах” чиглэлээр зохион байгуулан нийслэл, 21 аймаг, 9 дүүргийн 75 албан хаагчдыг хамруулан чадавхижуулсан.

Ховд, Орхон аймгуудад зохион байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтын хөтөлбөрт цахим худалдан авах ажиллагааны системийн танилцуулгыг оруулж тус системийн талаар сургалт зохион байгуулсан.

Мөн худалдан авах ажиллагааны талаар орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар 21 аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, албадад нийт 51 удаа албан бичиг хүргүүлж, утсаар мэдээлэл зөвлөгөө өгсөнөөс гадна, Орхон, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны албадуудад газар дээр нь хүрч ажиллан, үйл ажиллагаатай нь танилцаж, 18 аймгийг өөрийн байранд хүлээн авч зөвлөгөө, мэдээлэл

өгч гарын авлага тараах материалаар хангасан ба худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтыг 21 аймагт 1-3 удаа сургалт зохион байгуулж, 5000 гаруй иргэнийг хамруулан, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлсэн. “Цахим худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах” талаарх сургалтыг орон нутгийн худалдан авах ажиллагааны албадын ажилтнуудад 7 удаа зохион байгуулж, орон нутгийн 31 нэгжийн 447 албан хаагчийг хамруулсан.

Мөн "АРД ТҮМЭН ТА ХААН" форумын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар нь "Мерси Кор" ОУБ-тай хамтран Цахим худалдан авах ажиллагааны талаарх сургалтыг Blackboard системийг ашиглан орон зайн хамааралгүйгээр зохион байгуулж, 15 аймгийн Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн, иргэдийн төлөөлөгч, тендерт оролцогч 284 хүнийг хамрууллаа.

### Сургалт, сурталчилгааны ажлынчилгээ

Сангийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 84 тоот тушаалаар Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журамд өөрчлөлт орж Худалдан авах ажиллагааны газар нь АЗ төрлийн сургалт зохион байгуулахаас гадна Төрийн бус байгууллагуудад зохион байгуулж байгаа сургалтуудаас шалгалт авч гэрчилгээ олгох эрхтэйгээр шалгалт зохион байгуулан ажиллав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд төсвийн ерөнхий менежер, ажилтан нарын худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх сургалтыг захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулав.

1. Худалдан авах ажиллагааны газрын хэмжээнд 12 удаагийн сургалт зохион байгуулж, шаардлагатай албан хаагчдыг гэрчилгээжүүлсэн байна.
2. Дэлхий банкны санхүүжилтээр төрийн бус байгууллагуудын төлөөлөлд зориулан 4 удаа сургалт зохион байгуулж, худалдан авах ажиллагааны газраас байгуулсан үнэлгээний хороонд орж ажиллах 62 хүнд гэрчилгээ олгов.

Нийт 187удаагийн сургалтаас шалгалт авч, 7000 гаруй хүн хамрагдсанаас 3664 хүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтаны гэрчилгээ авсан байна.



“Худалдан авах ажиллагааны газар, Мерси Кор Монгол олон улсын байгууллага хоорондын хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулан “Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай болгох, худалдан авах ажиллагааны бодлого, түүний хэрэгжилтэнд иргэний нийгэм олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн салбар нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлэн

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтыг 15 удаа орон нутгийн ЗДТГ, ХААА-ны албан хаагчид, захиалагч байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, төрийн бус байгууллагын албан хаагчид, иргэдийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2013 оны төлөвлөгөөг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд ил тодзарлан мэдээлж олон нийтэд өрсөлдөх, тэгш боломжтой оролцох нөхцөлийг хангаж, үр дүнг нь нийтэд тайлагнан ажиллав. Энэ хүрээнд, Засгийн газрын худалдан авах ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний мэдээллийн систем /www.e-procurement.mn/, байгууллагын [www.e-tender.mn](http://www.e-tender.mn), [www.procurement.gov.mn](http://www.procurement.gov.mn), [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn) цахим хуудсанд ХААГ-аас 2013 онд зохион байгуулах төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг оруулж, 471 тендерийн урилга, гэрээ байгуулсан 275 ажлын үр дүнг тус системд ил тод, нээлттэй зарлан мэдээлсэн. Өдөр тутмын болон гадаадын этгээд оролцох тендерийн зарыг UB post сонинд 176 тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал, дахин зарласан урилга нийтлэж байна. Өдрийн сонин, Зууны мэдээ, UB Post сонинтой хамтран ажиллах жилийн гэрээ байгуулж дээрх сонинуудад тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал зэргийг тухай бүрд нь гаргуулж, төлбөр тооцоог гэрээнд заагдсан хугацаанд шилжүүлэх ажлын зохион байгууллаа.

Тендерийн нээлтийн ажиллагааг тухай бүрт олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ажиллаж байснаас ММ агентлаг, TV5, Eagle, TV9, C1, SBN, NTV, MN25 зэрэг телевизүүд, Өнөөдөр, Өдрийн сонин, Business times, Нийслэл таймс, Зууны мэдээ, Mongolian Economy зэрэг сонин, сэтгүүл болон [www.news.mn](http://www.news.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn), [www.vip76.mn](http://www.vip76.mn) зэрэг портал сайтуудад тухайн үеийн мэдээ мэдээллийг өгч ажиллав. Шинэчлэлийн засгийн газрын [www.zasag.mn](http://www.zasag.mn)–ний админий эрхийг албан ёсоор авч бүртгүүлэн, өөрийн газрын үйл ажиллагаа болон хийж буй ажлуудыгаа талаар тогтмол мэдээ оруулж, байгууллагын анимэйшн, холбогдолтой нэвтрүүлгүүдийг оруулж байна. Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээ олгох сургалтын шалгалтын 187 удаагийн дүнг тухай бүр нь нийтлэв.

2013 оны 12-р сарын 19-ны өдөр шилэн тендерийн эргэн тойронд яригдаж байгаа асуудлаар Худалдан авах ажиллагааны газрын удирдлагууд сэтгүүлчидтэй нээлттэй уулзалт – ярилцлага хийлээ. Тус уулзалтад хар жагсаалт, ерөнхий гэрээ, цаашид тендерийн будлианыг хэрхэн багасгах, төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэгчдийг хэрхэн дэмжих гэм мэт олон асуудлыг хөндлөө.



### Зохион байгуулсан томоохон арга хэмжээ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Монгол улсын Шадар сайдын эрхлэх хүрээний агентлагуудын ээлжит хуралдааныг зохион байгууллаа. Уг хуралдаанд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болох Худалдан авах ажиллагааны газар, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн



хяналтын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Оюуны өмчийн газар, Стандарт хэмжил зүйн газар тус тус оролцож агентлагуудын үйл ажиллагааны явц болон цаашид хийх үйл ажиллагааны чиглэлийн талаар санал солилцож, холбогдох мэдээ, мэдээллийг хүргэлээ. Хуралдааны үеэр Худалдан авах ажиллагааны газраас 2013 онд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний нэг болох “Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн Монголын талын хөрөнгө /Орхон, Эрдэнэт/-өөр барих цэвэрлэх байгууламжийн ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт болсон.



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын нээлтийн арга хэмжээг 2013 оны 05 сарын 09-ны өдөр зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, Шадар сайд Дэндэвийн Тэрбишдагва болон албаны бусад хүмүүс, Туркийн элчин сайдын яамны төлөөлөл, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, КОЙКА олон улсын байгууллага, МЕРСИ КОР олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн

байгууллагын төлөөлөлүүд оролцсон. Нээлтийн үйл ажиллагааны үеэр Худалдан авах ажиллагааны газрын дарга Д. Энхжаргал газрын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг хийсэн. Мөн нээлтийн арга хэмжээний үеэр Татварын Ерөнхий газар тендерт оролцогч аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн мэдээллийг ажлын 3 хоногт багтаан гарган өгч байхаар болсон нь онцлог явдал байсан.

Их хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, УИХ-ын гишүүн Б.Болор, Н. Батцэрэг, З. Баянсэлэнгэ, Зам тээврийн яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга нар, Архангай, Хэнтий аймгийн Засаг дарга нар, захиалагч агентлагын дарга удирдлагууд тус газрын үйл ажиллагаа, тендер шалгаруулалтын ажлын явц болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар ирүүлэх талаар санал солилцов.



Засгийн газрын худалдан авах ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг холбогдох хамтран ажиллагч байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Үүнд:

1. Монгол Улсын Шадар сайдын санаачилсан “Ард түмэн Та-Хаан 2013” Үндэсний форумын үндсэн болон дэд ажлын хэсгийг ахлан ажилласан,

2. 2013 оны 11 дүгээр сарын 20-22 өдрүүдэд ХААГ болон Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй хамтарсан “Төрийн худалдан авах ажиллагааны бодлого” уулзалт, семинарын бэлтгэл болон зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн,
3. 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр УИХ-ын эмэгтэй гишүүд тус газрын үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг өндөр хэмжээнд зохион байгуулсан,
4. 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилсан “Шинэчилье, шийдье 222” хэлэлцүүлгийн “Шилэн тендер-2014” арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж ажиллав.

Мөн ХААГ-ын нэг жилийн ойн арга хэмжээ, Орон нутгийн худалдан авах ажиллагааны албадын удирдах ажилтны сургалт-семинарыг зохион байгуулж, энэ талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, ХААГ-ын үйл ажиллагааны талаарх тараах материал, CD, нэг жилийн ажлын тайлан зэргийг бэлтгэн олон нийтэд тараан сурталчилав.

Худалдан авах ажиллагааны газрын Ажил, бараа, цахим болон зөвлөх үйлчилгээ худалдан авах хэлтсүүдийн мэдээллийг багтаасан АЗ 1/3-тэй тэнцэх хэмжээтэй брошурыг тус бүр англи, монгол хэл дээр хэвлүүлж, Нэг цэгийн үйлчилгээ болон олон нийтийг хамарсан үзэсгэлэнгийн үеэр тарааж, олон нийтэд мэдээлэл өгсөн.

## ДӨРӨВ. БУСАД АЖЛЫН ТАЛААР

### Нийгэм, соёлын олон талт арга хэмжээний талаар

Цагаан сар, Эмэгтэйчүүдийн баяр, Эрчүүдийн баяр, Эх үрсийн баяр, Үндэсний их баяр наадам, Шинэ жилийн баяраар нийт хамтолныг хамруулсан арга хэмжээг зохион байгуулснаар хамт олны дунд эвсэг, найрсаг уур амьсгалыг бүрдүүлж, албан хаагчдын хоорондын харилцааг сайжруулах, сэтгэл ханамжийг дээшлүүлэх хүчин зүйл болов.



Албан хаагчдын чөлөөт цаг, амралтыг зөв, зохистой өнгөрүүлэх зорилгоор 2013 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл амьдрал” сэдэвт цасныбаярын арга хэмжээг зохион байгуулж, хэлтсүүдийн хооронд тэмцээн уралдаан зохион байгуулав. Биеийн тамир спортыг хөгжүүлэх, ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 9 хүний бүрэлдэхүүнтэй “Спорт хамтлаг” байгуулж, 2013 оны 06 дугаар сарын 08-ны өдөр спортын 2 төрлөөр, шинэ жилийн баярыг угтаж, хэлтсүүдийн хооронд спортын 2 төрлөөр тэмцээн зохион байгуулж, аварга шалгаруулав.

2013 оны 10 дугаар сард Худалдан авах ажиллагааны агентлаг, нийслэл, дүүргийн газар, албадыг оролцуулсан сагсан бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож, тус байгууллагын эмэгтэйчүүдийн баг “Алтан медаль”, цомоор шагнуулсан амжилт гаргасан нь байгууллагын хамт олон спортыг дэмжиж, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд идэвхтэй анхаарч байгаагийн үр дүн гарав. Мөн дээрх зорилгоор албан хаагчид спорт зааланд долоо хоног бүр тоглож хэвшсэн.

Эх үрсийн баяраар албан хаагчдын 0-16 насны хүүхдэд мэндчилгээ дэвшүүлэх, бэлэг өгөх арга хэмжээг зохион байгуулав.

Байгууллагаа цэцэгжүүлэх 2 сарын аяны удирдамж, болзлыг боловсруулж газрын даргын А/130тоот тушаалаар батлуулан 200.0 төгрөгийн зардлаар аяныг зохион байгуулав. Өрөө тасалгааг цэцэгжүүлж, байгууллагын хэмжээнд нийт 100 гаруй цэцэг тарьж ургуулан “ногоон ажлын байр”-ыг бий болгоход анхаарч ажилласан нь ажиллагсдын ажиллах орчны өнгө үзэмж, таатай нөхцөл бий болов.

Байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, аж ахуйн ажлын талаар

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан 372.0 сая төгрөгөөр байгууллагын үйл ажиллагаанд ашиглах Ланд крузер 200 маркийн автомашиныг 106.0 сая төг, Соната 7 маркийн автомашиныг 38.7 сая төгрөгөөр худалдан авалт хийж, нийт ажиллагсдын тав тухтай орчныг бүрдүүлэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан хөрөнгөөр 131.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 96.2 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авч, хөрөнгө оруулалт хийв.

Цаг бүртгэлийн программ, санхүүгийн программ Винница, Acolous санхүүгийн программ, ABLE хүний нөөцийн программуудыг хэрэглээнд нэвтрүүлж, нийт 13,4 сая төгрөгийг зарцуулсан. Ингэснээр байгууллагын үндсэн хөрөнгө болох тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бараа материалын орлого, зарлагын бүртгэл хөтлөн санхүүгийн венница 3.5 програмд бүртгэн оруулав. Acolous 3.0 програмд үндсэн хөрөнгө тус бүрийг бүртгэн оруулж байна. Үндсэн хөрөнгө тус бүрийн гэрэл зургийг авч баримтжуулав. Үндсэн хөрөнгийн 560 056 380 төгрөгний худалдан авалт хийв. НягтланбодохбүртгэлийнОУ-ынстандартыг2013 оны 09-р сараас бүртгэлтайландаанэвтрүүлжэхэлсэнба 2013 оны 12 сарын 02-ныодортосовтбайгууллагуудадзориулагдсан Acolous 3.0 программыгсуулганстандартын дагуу бүртгэл хөтөлж байна.

2013 онд ХААГ-ын офиссын барилгын их засварт 137.1 сая төг, захиалагчийн техник хяналтын зардал 3.4 сая төг, зураг төсвийн үнэ 4.0 сая төгрөгийн зардлыг тус тус зарцуулав.

2013 оны төвлөрсөн төсвийн санхүүжилт 910.9 сая төгрөг, хөрөнгө худалдан авалт 400.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэв. Үүнээс цалинд, хоол унаа, НДШ - 543.7 сая төг, бичиг хэргийн зардалд -9.0 сая төг, тээвэр шатахууны зардалд-9.6 сая төг, шуудан холбоо-4.0 сая төг, гадаад томилолт-16.3 сая төг, ном хэвлэл захиалга-961.2 мян төг, төлбөр хураамж-3.5 сая төгрөг, харуул хамгаалалт-11.5 сая төг, урсгал засвар -232.9 сая төг, тавилга-86.1 сая төг, БҮТЭЗ-479.9 мян төг, программ хангамж-4.4 сая төг, мэдээлэл сурталчилгаанд-22.6 сая төг, сургалт семинарын зардалд-4.0 сая төг, шагнал урамшуулалд-1.7 сая төг, Жижиг мөнгөн сангаар 24.0 сая төг, үндсэн үйл ажиллагааны зардалд 98.1 сая төгрөгийн зардлыг тус тус гаргасан байна.

Тендерийн баримт бичиг худалдсан орлогоос үнэлгээний хороо, тендер зохион байгуулахтай холбогдон гарах зардлаас Төрийн бус байгууллагуудын үнэлгээний хорооны гишүүдэд урамшуулал олгож, нийт 22 гишүүнд 11,8 сая төгрөгийн урамшууллын гүйлгээ хийв. Үлдсэн 15 төрийнбусбайгууллагын 22 хүндуррамшуулалолгохоорхолбогдохтооцоогхийжбайна.ТББ гэрээнд заагдсан гишүүдийн оролцсон ажил бүрээр нэг бүрчлэн гаргаж, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нараар гарын үсэг зурж баталгаажуулсан.

Байгууллагын дулааны узелийг сольж, засварлан хэвийн үйл ажиллагааг хангав. 12 удаа байгууллагын дотор их цэвэрлэгээ, 12 удаа байгууллагын гадна талбайн их цэвэрлэгээ хийгдэв.

## ДҮГНЭЛТ

Худалдан авах ажиллагааны газар байгуулагдаад нэг жилийг өнгөрөөж буй энэ хугацаанд “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны алба байгуулах тухай Засгийн газрын тогтоол, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр “Худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт” батлуулах зэрэг томоохон ажлуудыг богино хугацаанд хийж гүйцэтгэснээс гадна шинэ тутам байгууллагын чадавхийг бэхжүүлэх талаар гадаад, дотоодын олон байгууллагатай харилцаа, холбоо тогтоон тодорхой ахиц гарган ажиллав.

Шинээр байгуулагдсан тус газар нь 2013 онд улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулагдах нийт 345 ажлыг зохион байгуулах жагсаалтыг Монгол Улсын Засгийн газраар батлуулж, Төсвийн ерөнхийлөн захирагч бүртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөөгөө батлуулан ажилласан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” төр засгийн бүх шатанд хэрэгжиж буйг харуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод, шударга байдлыг хангах талаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар, Авлигатай тэмцэх газар болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байгаа нь хариуцлагаа ухамсарласан, цаашид гарах аливаа асуудлаас урьдчилан сэргийлэх чухал алхам болсон.

Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор [www.procurement.gov.mn](http://www.procurement.gov.mn), [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) вэб хуудсыг ажиллуулж, төсөл, арга хэмжээний урилга, явц, үр дүнгийн талаарх мэдээллийг цаг алдалгүй оруулж, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй шуурхай мэдээлж ажилласнаар тендертэй холбоотой гомдол маргаан буурсанба ТЭЗҮ, зураг төсөлтэй, батлагдсан төсөвт нь багтсан тендер зарлагдаж, шаардлага хангасан оролцогчийн тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч байгаа нь тендерийн үнэлгээтэй холбоотой аливаа гомдол, маргаан өмнөх жилүүдээс буурах нөхцөл болсон.

Татварын ерөнхий газраас тендерт оролцож буй аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхитай холбоотой мэдээллийг авч ажилласнаар аж ахуйн нэгж, байгууллагууд татвараа хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнадаг болсон.

“Барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааны ISO-10845 олон улсын стандарт”-ыг Стандарчлал хэмжил зүйн техникийн Үндэсний хороогоор батлуулсан нь Монгол улсын худалдан авах ажиллагааг анх удаа MNS-10845 олон улсын стандартын дагуу зохион байгуулах боломж бүрдсэн.

“Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Цахим худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөр” батлагдан сургалтууд зохион байгуулагдан, орон нутгийн Худалдан авах ажиллагааны нэгжүүдийн ажилтнууд худалдан авах ажиллагааны сургалтанд 100 хувь хамрагдсан.

Худалдан авах ажиллагааны газар нь Дэлхийн банктэй “Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн хүрээг боловсронгуй болгох”, “Худалдан авах ажиллагааны



чадавхийг сайжруулах” төсөл, КОЙКА олон улсын байгууллагатай “Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх” төсөл, МЕРСИ КОР олон улсын байгууллагатай “Засгийн газрын худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай болгох, худалдан авах ажиллагааны бодлого, түүний хэрэгжилтэнд иргэний нийгэм, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн салбар нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх” төслүүдийг хамтран хэрэгжүүлсэн.

Худалдан авах ажиллагааны талаар цуврал хөдөлгөөнт зурмал, цуврал нэвтрүүлгийн 5 ангийг бэлтгэж, иргэдэд хүргэсэн.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн дүгнэлт болох 2013 оны 13 ажлыг дор дурдсанаар онцлон нэрлэж байна. Үүнд:

1. Шууд гэрээ байгуулах ажлын хэсгийг байгуулж ажилласан,
2. Цахим мэдээллийн санг бий болгосон,
3. Цахим тендер зохион байгуулсан,
4. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн албан хаагчийн АЗ гэрчилгээг олгосон,
5. Авлигаас ангид байх эрмэлзэл буюу удирдлагын манлайлал,
6. “Нэг цэгийн үйлчилгээний төв”,
7. Худалдан авах ажиллагаанд ОУ-ын стандартыг мөрдөх боломж бий болгосон,
8. Цуврал анимэйшн,
9. Мерси Кор ОУБ-тай хамтран зохион байгуулсан орон зайн хамааралгүй цахим сургалт,
10. Байгууллагын 1 жилийн ойн үеэр нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан-хэлэлцүүлэг зохион байгуулсан,
11. Европын Холбоо, Европын Сэргээн Босголтын Банкны дэмжлэгтэйгээр олон улсын уулзалт семинарыг зохион байгуулсан,
12. Орон нутгийн удирдах ажилтны сургалт – семинар зохион байгуулсан.
13. “Шилэн тендер – 2014” арга хэмжээний хүрээнд сэтгүүлчидтэй уулзалт – ярилцлага зохион байгууллаа.

Онцлох 13 ажлын танилцуулгыг энэхүү тайланд тодруулан хавсаргав.

### ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

- Тендерт оролцогдод худалдан авах ажиллагааны мэдлэг олгох, цахимаар худалдан авах ажиллагаанд оролцох чадвар эзэмшүүлэх, худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Хөрөнгө оруулалтын үр дүн, цаашид хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, бусад төсөл, арга хэмжээтэй уялдуулан

- төлөвлөх зорилгоор Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын дэргэд Сургалт, судалгааны төвийг байгуулж ажиллуулах,
- “Монгол улсад цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх төсөл”-ийн II үе шатыг эхлүүлэх,
  - Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжийг мэргэжлийн шуурхай удирдлагаар хангах бололцоог бүрдүүлэх,
  - Худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан олон нийтийг Засгийн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр хангаж, ил тод байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх,
  - Засгийн газрын худалдан авах ажиллагаанд нээлттэй, үр ашигтай, шударга, ил тод байдлыг хангах боломжийг бүрдүүлэх, тендер шалгаруулалтыг зохион байгуулах зардлыг багасгах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, улсын төсвийг үр ашигтайгаар зарцуулах, түүнд тавигдах хяналтыг дээшлүүлэх.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Ч.ЖАРГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ